



“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

/2025 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар/

"Монголын хөрөнгийн бирж" ХК нь Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу 2022 оны 12 дугаар сард нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй арилжин нийт 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн билээ.

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар үнэт цаасны танилцуулгад тодорхой тусгасан бөгөөд компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн болно.

Хүснэгт №1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

№	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	
1	Арилжааны систем сайжруулалт	63.7%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	10.7%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	6.1%
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	19.5%
Нийт		100.0%

Компани 2025 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 4,235.7 сая төгрөгийн зарцуулалт хийхээр төлөвлөсөн бөгөөд үүнд:

- Арилжааны дэд бүтэц болох МIТ системийн арилжааны, хяналтын программ хангамж болон техник хангамжийн шинэчлэл, хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, арилжих системийн нэвтрүүлэлт, design study зэрэгт нийт 3,729.9 сая төгрөг;
- Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай лиценз (Fortinet, Endpoint, Data Loss Prevention, Privileged Access Management) худалдан авахад нийт 164.8 сая төгрөг;
- Дотоод үйл ажиллагааг цахимжуулах зорилгоор дундын мэдээллийн сангийн систем нэвтрүүлэх ажилд 200.0 сая төгрөг;
- Хөрөнгийн зах зээлийн сургалт, үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгоход 140.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тус тус хийхээр төлөвлөсөн болно.



2025 онд татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 4,235.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс тайлант хугацаанд Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Fortinet болон Endpoint лиценз худалдан авахад 43.4 сая төгрөг, Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор батлагдсан зураг, төсвийн дагуу дэлгэц худалдан авах, барилгын гадна усны хаялгын ажилд нийт 137.5 сая төгрөг, нийт 180.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт №2. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан 2025.09.30 /мян.төг/

№	Бараа, ажил үйлчилгээний нэрс	Төлөвлөгөө		2025 он		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл 2025.09.30	
		Дүн	Хувь	Дүн	Дүн	Хувь
1	Арилжааны системийн сайжруулалт	7,590,339	64%	3,729,986	-	-
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	1,274,986	11%	164,840	43,395	3%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	726,861	6%	200,000	-	-
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор барилга байгууламжийн дотоод зохион байгуулалтын өөрчлөлтөд оруулах хөрөнгө оруулалт	2,323,573	20%	140,971	137,490	6%
Нийт		11,915,760	100%	4,235,797	180,885	2%

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдаж авах ажиллагаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон компанийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зориулалтын дагуу үе шаттайгаар хэрэгжиж байгаа болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК